

Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдоржийн хариулт

Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдорж TIME.MN-ийн таван асуултад хариулт ирүүллээ.

1.Одоо 330 мянга гаруй иргэнд сая төгрөг бэлнээр тараана. Үүнийг дагаад инфляци өсөх хүлээлт бий. Монголбанк ямар арга хэмжээ авах вэ?

-Тус мөнгөний эх үүсвэр нь хаанаас гарч байна вэ гэдэг нь чухал. Хэрвээ Засгийн газар энэ мөнгийг дотоод санхүүгийн захаас босгож байвал гарч болох сөрөг үр дагавар нь харьцангуй бага. Харин мөнгөний нийлүүлэлтийг нэмэх замаар зохицуулалт хийвэл энэ нь инфляцийн дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Мөнгө тараана гэсэн зар нь өөрөө инфляцийн хүлээлтийг нэмэгдүүлэх сөрөг үр дагавартай байдаг. Иймээс Монголбанк нөхцөл байдлыг анхааралтай ажиглаж байгаа бөгөөд тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажиллах болно.

2.Инфляцийн эсрэг бодлогын хүүг өсгөхөөс өөр арга хэрэгсэл ашиглаж болдоггүй юм уу?

-Төв банк мөнгөний бодлогын шийдвэр гаргалтад инфляцийн цаашдын өрнөлийг харгалзахын зэрэгцээ дунд хугацааны макро эдийн засгийн тогтвортой байдлыг бүхэлд нь авч үздэг. Иймд мөнгөний бодлогын шийдвэр нь одоогийн байгаа байдал ирээдүйд яаж өөрчлөгдөх, түүнд ямар байдлаар нөлөөлөх вэ гэдэг шийдвэр юм. Иймээс мөнгөний бодлогыг хатууруулж буйг зөвхөн бий болсон инфляцийн эсрэг арга хэмжээ гэж ойлгох нь буруу юм.

Түүнчлэн, Монголбанк мөнгөний бодлогыг хатууруулах арга хэмжээг авахдаа дан ганц бодлогын хүүг өсгөж байгаа юм биш. Монголбанк мөнгөний бодлогын хүү, банкуудын заавал байлгах нөөц, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, системийн эрсдэл даах чадамжийг хослуулан, харилцан уялдаатай аргуудыг хэрэглэж ирсэн. Эдийн засгийн нийт эрэлтийн байдал, санхүүгийн зах зээлийн нөхцөлтэй уялдуулан Монголбанк 2009 оноос эхлэн бодлогын хүүг есөн удаа өсгөж, гурван удаа бууруулахдаа заавал байлгах нөөцийн хувийг гурван удаа өсгөж, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг нэмэгдүүлж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээг хослуулан авсан. Мөн төв банкнаас банкуудад олгох, авах зээлийн хүүний бүтцийг өөрчлөн, бодлогын хэрэгслүүдийн өөрчлөлтийг илүү нэгдмэл, харилцан уялдаатай болгох зорилгоор хоёр удаа шат дараатай өөрчиллөө. Санхүүгийн зах зээлд тогтворгүй байдал үүсгэх банкнаас гадуурх эрсдэлүүдийг хязгаарлах үүднээс УИХ, Засгийн газар, Сангийн яаманд хандаж тайлбар хүргүүлж, зохих арга хэмжээ авахыг зөвлөж, хамтран арга хэмжээ авахад оролцож ажилласан.

Мөнгөний бодлогыг чангаруулахдаа яагаад голчлон бодлогын хүүг өсгөх аргыг хэрэглэж байгаа вэ гэвэл, нэгдүгээрт, бодлогын хүүг өөрчлөх нь мөнгөний бодлогын төлөв ямар чигт байгаа болон төв банк макро эдийн засгийн нөхцөл байдлыг хэрхэн харж байгаа талаар олон нийтэд сайн дохио болдог. Хоёрдугаарт, мөнгөний бодлогын бусад арга хэрэгслүүд нь илүү захиргааны шинж чанартай байдаг бол бодлогын хүү нь зах зээлд суурилж, мөнгөний бодлогын шилжих механизмаар дамжин илүү өргөн цар хүрээг хамарч, нийт эдийн засагт нөлөөлөх чадвартай байдгаараа онцлог юм. Гуравдугаарт, гадаад валюттай харьцах төгрөгийн ханшийн хэлбэлзлийг багасгах зорилгоор интервенци хийж байгаа үед төгрөгийн өгөөжийг өндөр байлгахын тулд бодлогын хүү өөрөө өндөр байх шаардлагатай болдог.

3.Төв банк төсөв, сангийн бодлого уялдаагүйгээс үүдсэн “үр дагавар”-тай голчлон тэмцэж байна. Үүний оронд “шалтгаан”- тай нь тэмцвэл илүү үр дүнтэй биш үү?

-Засгийн газрын шийдвэр төрийн мөнгөний бодлогод харшилж байвал Монголбанк энэ талаар Засгийн газарт мэдэгддэг хуультай. Хуулийн хүрээнд төв банк Засгийн газарт удаа дараа инфляцийн дарамт өсөх эрсдэлтэй байгааг анхааруулан саналаа хүргүүлж байсан. Хоёр жилийн өмнөөс буюу 2010 оны тавдугаар сард Монголбанк

-Дотоод зах зээл дээрх махны нийлүүлэлтийн хомсдолыг багасгах үүднээс махны экспортыг тухайн ондоо зогсоох;

-Махны үнийн өсөлтийг зогсоож, бууруулахын тулд махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах;

-Бэлэн мөнгө, тэтгэмж олгохоо зогсоож, сонгуулиар амласан тэтгэмжээ зөвхөн бэлэн бус хэлбэрээр олгох;

-Хувийн секторын хөрөнгө оруулалт, дуусаагүй үйлдвэрлэлийг дэмжсэн төсвийн бодлогыг банкны бүтцийн өөрчлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна гэсэн анхааруулгыг Засгийн газарт явуулж байв. Дараа нь 2011 оны арванхоёрдугаар сард Засгийн газарт, энэ оны дөрөвдүгээр сарын 18-нд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хандан албан бичиг, анхааруулга илгээсэн. Энэ мэтээр тоочвол олон зүйл байгаа. Эндээс төсөв, мөнгөний бодлого яагаад уялдаагүй байгаа нь тодорхой харагдаж байгаа байх. Харин инфляци өсөөд эхэлбэл Монголбанк хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхээс өөр аргагүй.

4.Төв банк төгрөгийн тогтвортой байдлыг хангах үүргээ бүрэн дүүрэн биелүүлж чадаж байгаа юу?

-Төв банкны үндсэн зорилт болох “Үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах” гэдэг нь үнийн тогтвортой байдлыг хангах зорилт бөгөөд төгрөгийн валюттай харьцах ханшийг тогтвортой барих тухай ойлголт огт биш гэдгийг энд зориуд цохон тэмдэглэе. Төгрөгийн валюттай харьцах ханш нь нэгж валютыг төгрөгөөр худалдан авах үнэ бөгөөд энэ нь Монгол Улсын макро эдийн засгийн суурь нөхцөлөөр тодорхойлогдон, валютын зах дахь эрэлт, нийлүүлэлтээс хамаарч уян хатан тогтож байдаг. Монголбанк төгрөгийн валюттай харьцах ханшийг тодорхой түвшинд онилж барьдаггүй. Мөн барих гэж оролдох нь ч зохисгүй. Харин уян хатан ханшийн бодлогыг хэрэгжүүлэх, валютын захын тогтвортой байдлыг хангах үүргээ тууштай, бүрэн дүүрэн биелүүлж байгаа.

5.Сүүлийн үед гадаад валютын эрэлт, нийлүүлэлт тэнцвэртэй байгаа. Цаашид тогтвортой байдал удаан хадгалагдах боломжтой юу?

-Валютын зах дахь эрэлт, нийлүүлэлт тэнцвэртэй байгаа. Ийм үед Монголбанкнаас валютын захад оролцох шаардлага гардаггүй. Харин богино хугацааны эрэлт, нийлүүлэлтийн зөрүү үүссэн үед захын тогтвортой байдлыг хангах, ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор

Монголбанкнаас валютын захад оролцдог. Оны эхнээс авч үзэхэд ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.23 хувь байгаа нь валютын зах тогтвортой байгааг илэрхийлж байна. Цаашид ханш тогтвортой байх төлөвтэй байна.

Валютын ханш уян хатан тогтож, эдийн засагт бий болж буй нөлөөллүүдийг өөртөө шингээх нь макро эдийн засгийг хямралын эрсдэлээс хамгаалахад чухал нөлөөтэй дархлаа байдаг. Валютын ханшийг тодорхой түвшинд барих гэж оролдох нь манайх шиг урсгал тэнцлийн алдагдалтай орны хувьд ихээхэн эрсдэл дагуулсан, өнөө маргаашаа харсан, улс төржсөн шинжтэй буруу үйлдэл юм. Хэдийгээр валютын ханшаа тогтмол түвшинд барьдаг улс орнууд цөөнгүй байдаг ч тэдгээр улсууд нь урсгал тэнцлийн ихээхэн ашигтай, ханш чангарах дарамт байнга байдаг, өрсөлдөх чадвараа хадгалахын тулд ханшаа чангаруулахгүй байх зорилгоор интервенци хийж, валютын нөөцөө өсгөдөг. Цаашид Монголбанкны зүгээс валютын ханш макро эдийн засгийн суурь нөхцөлөөр тодорхойлогдон, валютын зах дахь эрэлт, нийлүүлэлтээс хамаарч уян хатан тогтож байх зарчмаа тууштай хэрэгжүүлнэ.